



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2011 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/90

Алтай хот

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Цогт сумын ариутгах татуургын төв шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Д.Гаадамба	-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	А.Сарантуяа	-(Соёл, урлагийн газрын Соёл урлагийн хэлтсийн дарга)
	Г.Ууганбаатар	-(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
Нарийнбичиг:	Б.Эрдэнэчулуун	-(Есөнбулаг сумын иргэн)
	Б.Батнайрамдал	-(Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Д.Гаадамба)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Д.АЛТАНЗАГАС

